

Давтан Үнэлгээ Төлөвлөх Уулзалт: Гэр бүл/Асран Хамгаалагчдын Мэдлэгт

Сурагчийн Нэр:

Огноо:

Давтан Үнэлгээ Төлөвлөх Уулзалт гэж юу вэ?

Сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг тусгай боловсролын үйлчилгээний шаардлага хангаж буйг тогтоохын тулд гурван жил тутамд наад зах нь нэг удаа давтан үнэлгээ хийх ёстой. Үүнээс өмнө давтан үнэлгээ төлөвлөх уулзалт зохион байгуулж, хуучин байгаа мэдээлэл, өгөгдлийг шалгаж, шинэ үнэлгээ шаардлагатай эсэхийг шийднэ. Энэ уулзалт нь эцэг эх болон сургуулийн ажилтнууд хамтран одоогийн мэдээллийг хэлэлцэх, санаа зовоож буй асуудлуудаа хуваалцах, дараагийн алхмыг төлөвлөх боломжтой цаг юм. Хэрэв шинэ үнэлгээ хэрэгтэй гэж үзвэл, сургууль нь эцэг эхийн зөвшөөрөл авч байж үнэлгээг эхэлнэ.

Хэрэв IEP багийн хэн нэгэн (эцэг эх оролцуулан) хүсэлт гаргавал энэ уулзалтыг гурван жилийн дотор хэдэн ч удаа зохион байгуулж болно. Ойр давтамжтай уулзалт хийх шалтгаануудад шинэ мэдээлэл эсвэл тайланг хянах болон/эсвэл сурагчийн одоогийн боловсролын хэрэгцээний талаар дэлгэрэнгүй хэлэлцэх зэрэг байж болно.

Давтан үнэлгээ төлөвлөх уулзалтад хэн оролцдог вэ?

- Та (эцэг эх, асран хамгаалагч)
- Танай хүүхдийн багш нар (ерөнхий болон тусгай боловсрол)
- Сургуулийн захирал эсвэл туслах захирал (эсвэл тэдний томилсон төлөөлөгч)
- Хэрэв танай хүүхэд холбогдох үйлчилгээ авсан бол холбогдох үйлчилгээ үзүүлэгчид (хэл яриа, хөдөлмөр засалч гэх мэт) Сургуулийн сэтгэл зүйч
- Сургуулийн нийгмийн ажилтан
- Сурагч Дэмжих Зохицуулагч (SSC) Хэрэв зохимжтой бол таны хүүхэд
- Таны эсвэл сургуулиас урьсан бусад хүмүүс

Бид юу хэлэлцэх вэ?

Таныг оролцуулсан баг дараах асуудлуудыг тодорхойлох үүднээс ангийн гүйцэтгэл, стандартчилагдсан шалгалтын оноо, багшийн тайлан, холбогдох үйлчилгээ үзүүлэгчийн тэмдэглэл, өмнөх үнэлгээг хянаж, цаашид шалгалт хийх шаардлагатай эсэхийг хэлэлцэнэ. Эдгээрт:

- Танай хүүхдийн тусгай боловсролын үйлчилгээнд хамрагдах эрх хэвээр байгаа эсэх
- Танай хүүхдийн одоогийн суралцах хэрэгцээ
- Хүүхдийн тань сурлага, өсөлт хөгжлийн явц зэрэг болно.

Хэрэв баг одоо байгаа мэдээлэл нь эрх хангалтыг тогтоох, үзүүлэх үйлчилгээг тодорхойлоход хангалттай гэж үзсэн бөгөөд таныг зөвшөөрсөн нөхцөлд дахин шинээр үнэлгээ явуулахгүйгээр давтан үнэлгээг хааж болно.

Ямар шийдвэр гаргах вэ?

Баг хамтарч дараах зүйлсийг шийднэ.

- Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээнд хамрагдах эрх тодорхойлохын тулд ямар нэгэн шинэ үнэлгээ, мэдээлэл шаардлагатай эсэх
- Хэрэв баг үйлчилгээнд хамрагдах эрх тодорхойлоход хангалттай өгөгдөл/мэдээлэл байгаа гэж үзвэл тухайн баг хурлын үеэр эрх тодорхойлох шийдвэр гаргаж болно. Танай хүүхдийн үйлчилгээний эрхэд өөрчлөлт оруулах, эсвэл тусгай боловсролын үйлчилгээнээс хасахын тулд таны зөвшөөрөл шаардлагатай.

Давтан Үнэлгээ Төлөвлөх Уулзалтад Эцэг эх/ Асран хамгаалагч ямар үүрэгтэй оролцох вэ?

- Шинэчилсэн үнэлгээ шаардлагатай эсэхийг бодолцож үзээрэй.
- Уулзалтын үед яриа хэлэлцүүлэгт идэвхтэй оролцоорой. Жич: Хэрэв танд хэлмэрч ба/эсвэл уулзалтад оролцоход ADA хөнгөлөлт шаардлагатай бол энэ тухайгаа сургуульдаа мэдэгдэнэ үү.
- Өөрийн санаа, бодол, санаа зовоосон асуудлуудаа чөлөөтэй хуваалцаж болно.
- Шаардлагатай бол асуулт асууж, тодруулга аваарай.
- Санал болгож буй шинэ үнэлгээг зөвшөөрөх эсэхээ шийдэх.

Жич: Сургууль давтан үнэлгээ явуулахын тулд таны зөвшөөрөл шаардлагатай.

Гэвч хэрэв сургууль таны зөвшөөрлийг авахаар бүхий л хүчин чармайлт гаргасан боловч та хариу өгөөгүй бол сургууль үнэлгээг гүйцэтгэж болно.

Давтан Үнэлгээ Төлөвлөх Уулзалтад бэлдэх



Уулзалтад бэлтгэлтэй, өөртөө итгэлтэй очих зарим зөвлөмж:

- ✓ Сүүлийн үеийн дүнгийн хуудас, IEP-ын явцын тайлан, үнэлгээний мэдээлэл, тайланг хянаж, цэгцлэх. IEP явцын шинэчилсэн тайлан болон дүнгийн хуудаснууд ParentVue-д бий.
- ✓ Хэрэв танд багтай хуваалцахыг хүсэж буй ямар нэгэн хувиараа хийлгэсэн үнэлгээний дүн зэрэг мэдээлэл байгаа бол эдгээрийг уулзалтаас өмнө илгээнэ үү.
- ✓ Хүүхдийнхээ үйлчилгээнд эрх хангасан эсэх эсвэл боловсролын хэрэгцээг тодорхойлоход нэмэлт шалгалт шаардлагатай эсэхийг бодолцож үзээрэй. Хэрэв та үнэлгээ шаардлагатай гэж үзэж байгаа бол ямар үнэлгээ шаардлагатайг тэмдэглэх, улмаар багтай энэ тухай санал бодлоо хуваалцаарай.
- ✓ Хуваалцахыг хүссэн сэтгэгдэл/тэмдэглэлээ дараах "Ярилцах Сэдэв" хэсэгт бичнэ үү.
- ✓ Уулзалтын үеэр асуухыг хүссэн асуултуудаа дараах "Асуулт" хэсэгт жагсааж бичнэ үү.
- ✓ Хэрэв та уулзалтад хэн нэгнийг (найз, өмгөөлөгч, гэр бүл г.м) оролцуулахаар төлөвлөж байгаа бол энэ тухайгаа сургуульдаа урьдчилан мэдэгдсэнээр нэмэлт зай, материал бэлтгэх боломжтой юм.
- ✓ Уулзалтад бэлтгэхэд тусламж хэрэгтэй бол 703.228.7239 утсаар эсвэл prc@arpsva.us хаягаар Эцэг Эхчүүдийн Мэдээллийн Төвтэй холбогдоно уу.

Асуух Асуултууд	Ярилцах Сэдэв /Нэмэлт Асуулт
• Уулзалтаас боломжит ямар үр дүнгүүд гарч болох вэ? • Багаас үйлчилгээний эрх тодорхойлоход туслах ямар өгөгдлүүд байгаа вэ? • Хэрэв баг шинэ үнэлгээ хийх шаардлагатай гэж үзвэл тухайн шинэ үнэлгээ ямар зорилготой байх вэ? • Өнөөдрийн уулзалтын хэлэлцүүлэг нь манай хүүхдийн одоогийн IEP дэмжлэг/үйлчилгээнд нөлөөлөх эсэх?	

ДЭЛГЭРЭНГҮЙ

PRC танд туслахад бэлэн байна.
Бидэнтэй 703.228.7239 утсаар
эсвэл prc@arpsva.us хаягаар
холбогдоно уу.



PEATC: Эцэг
Эхийн Эрх



PEATC:
Үнэлгээний Тухай
Ойлголт



VDOE: Давтан
Үнэлгээний тухай
Видео



PEATC:
Давтан Үнэлгээ



VDOE: Гэр
Бүлүүдийн Тусгай
Боловсролын
Гарын Авлага